

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын 2020 оны 02-аар сарын 20-ны өдрийн А/08 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГЫН ХАРИУЦАЖ БУЙ ОРОН СУУЦ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭГ БҮРТГЭХ ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Орон сууцны барилгын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын хариуцаж буй барилга байгууламж, үйлчилгээний хамрах хүрээг Зохицуулах зөвлөлийн мэдээллийн санд бүртгэх, түүнийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих, холбогдох бүртгэл, судалгааг тайлагнахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Энэхүү журам нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад нийцсэн байна.

Хоёр. Орон сууцны барилга байгууламжийг бүртгэх

- 2.1 Зохицуулах зөвлөл нь орон сууцны барилга, байгууламжийн бүртгэлийг мэдээллийн санд бүртгэн, хяналт тавина.
- 2.2 Барилга байгууламж, үйлчилгээний хамрах хүрээг бүртгүүлэх хүсэлтийг Зохицуулах зөвлөлийн ажлын алба хүлээн авч, газар дээр нь очиж ажиллан, холбогдох хуульд заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.
- 2.3 Бүрдүүлсэн бичиг баримт шаардлага хангасан өдрөөр тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад бүртгэж, мэдээллийн санд оруулна.

Гурав. Бүрдүүлэх бичиг баримт

- 3.1 Барилга байгууламжийн захиалагч нь орон сууцны барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулсаны дараа тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад ашиглалт, үйлчилгээг шилжүүлэх хүсэлтийг Зохицуулах зөвлөлд ирүүлнэ.
- 3.2 Захиалагчийн хүсэлтийг үндэслэн Зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 2.6.4-ийн 3-д заасны дагуу тухайн барилга, байгууламжид ойролцоо байрлалд байрлах, хэрэглэгчдэд засвар үйлчилгээг түргэн, шуурхай үзүүлэх боломжтой тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “ТЗЭ” гэх) байгууллагуудын мэдээллийг ажлын 5 хоногт багтаан захиалагч байгууллагад санал болгоно.
- 3.3 Зохицуулах зөвлөлийн санал болгосон ТЗЭ байгууллагуудаас захиалагч нь сонголтыг хийж, тухайн ТЗЭ байгууллагатай ашиглалт, үйлчилгээний гэрээг байгуулж, барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг шилжүүлнэ.

- 3.4 Гэрээг үндэслэж тухайн барилга, байгууламжийг Зохицуулах зөвлөлийн мэдээллийн сан болон ТЗЭ-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад бүртгэнэ.
- 3.5 Барилга байгууламж, үйлчилгээний хамрах хүрээг мэдээллийн сан болон гэрчилгээний хавсралтад бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
- 3.5.1 ТЗЭ-ийн албан хүсэлт /шинээр бүртгүүлэх барилга, байгууламжийн хаяг, айл өрх, аж ахуйн нэгжийн тоо тодорхой тусгагдсан байна/;
- 3.5.2 "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ-ын тодорхойлолт /дамжин хэрэглэгч эсэх талаар, мөн аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх эсэх талаар болон 3.5.3-т заасан заалтаар/;
- 3.5.3 "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ болон "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-иас олгосон техникийн нөхцөл, түүний хэрэгжилт хангагдсан эсэх;
- 3.5.4 Барилга байгууламжийг ашиглалтад хүлээж авсан комиссын акт, дүгнэлт;
- 3.5.5 Энэ тушаалын хоёрдугаар хавсралт дахь хүснэгт;
- 3.6 Хэрэв бичиг баримтын бүрдэлт шаардлага хангаагүй бол Зохицуулах зөвлөлийн ажлын албанаас энэ тухай албан бичгээр хариу өгнө.

Дөрөв. Тайлагнах

- 4.1 Тусгай зөвшөөрлийн алба нь барилга, байгууламжийн бүртгэлтэй холбоотой тайлан, мэдээ, судалгааг улирал бүр нэгтгэн, даргын зөвлөлийн хуралд танилцуулна.
- 4.2 Ажлын алба ТЗЭ-дийн барилга байгууламж, үйлчилгээний хамрах хүрээний бүртгэлийн тайланг жилийн эцсийн дүнгээр гарган, Зөвлөлийн нэгдсэн тайланд оруулна.

Тав. Бусад зүйл

- 5.1 Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, барилга байгууламжтай холбоотой өмчийн аливаа маргаантай асуудлыг энэхүү журмаар зохицуулахгүй.

--- о О о ---

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын 2020 оны 02-аар сарын 08-ны өдрийн А/08 дугаар тушаалын хоёрдугаар хэвсрэлт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ХАРИУЦАЖ БУЙ
ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН БҮРТГЭЛ

.... он сар өдөр

№	Нэр				Байрны дугаар /нэр/	Тоо	
	Орон нутаг	Сум, дүүрэг	Баг, хороо	Гудамж, хотхон		Өрх	ААНБ

Дарга / Захирал /:

/гарын үсэг/

Овог, нэрийн тайлал

/...../

Албан тушаалын нэр

Боловсруулсан:

.....

/гарын үсэг/

Овог, нэрийн тайлал

/...../

Албан тушаалын нэр

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын 2020 оны 02-аар сарын 08-ны өдрийн А/08 дугаар тушаалын гуравдугаар хэвсрэлт¹

"....." ХХК барилга байгууламж шинээр бүртгүүлэх

Үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн
1.	Хэрэглэгчийн тоо	Айл өрх	тоо
2.		ААНБ	тоо
3.	Борлуулах ус	мян.м3	
4.	Үйлчилгээ үзүүлэхийн тулд туулах зам	км	
5.	Бохир усны насостой эсэх		
6.	Насосны марк, хүчин чадал		
7.	Дамжин хэрэглэгч эсэх		
8.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211, 2021 оны 207 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор Зохицуулах зөвлөлтэй тооцооны үлдэгдлийн баталгаа хийж, гэрээ байгуулсан эсэх.		

Ашиг/алдагдлын тооцоо

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн /сараар/	Дүн /жилээр/
1.	Үндсэн цалин ба ЭМ, НДШ-н зардал	мян.төг		
2.	Ус худалдан авах зардал	мян.төг		
3.	Ашиглалтын зардал /цахилгаан, дулаан/	мян.төг		
4.	Засвар үйчилгээний зардал	мян.төг		
5.	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	мян.төг		
6.	Ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	мян.төг		
7.	Бусад зардал	мян.төг		
8.	Бүгд зардал	мян.төг		
9.	Борлуулалтын орлого	мян.төг		
АШИГ, АЛДАГДАЛ		мян.төг		

Хангагч, хэрэглэгчийн авлага, өглөгийн тооцоо

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн /тайлант жилээр/	Тайлбар
1.	Авлага	мян.төг		
2.	Өглөг	мян.төг		

Тамга:

Дарга /Захирал//...../

Ерөнхий нягтлан бодогч/...../

¹ /Зохицуулах зөвлөлийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны А/16 дугаар тушаалаар нэмэлт оруулсан./